

Үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 11
дүгээр сарын 4-ний өдрийн 01/137 тоот тушаалын
хавсралт

БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДАНС
БАЙГУУЛАХ АРГАЧЛАЛ

Улаанбаатар хот

2009

Агуулга

1. Нийтлэг үндэслэл	4
2. Ойлголт, тодорхойлолт	4
3. Данс байгуулахад ашиглах ангилал	5
4. Бараа, үйлчилгээний данс, түүний үзүүлэлт	6
5. Бараа, үйлчилгээний дансанд бүтээгдэхүүнийг үнэлж, бүртгэх.....	20
6. Бараа, үйлчилгээний данс байгуулах мэдээллийн эх үүсвэр	24
7. Бараа, үйлчилгээний данс аа бусад макро эдийн засгийн үзүүлэлт	25
Хавсралт 1. Данс 0: Бараа, үйлчилгээний данс, дэлгэрэнгүй байдлаар.....	28
Хавсралт 2. Бараа, үйлчилгээний хураангуй дансны жишээ	29

Товчилсон үгийн тайлбар

ҮТС - Үндэсний тооцооны систем

ДНБ - Дотоодын нийт бүтээгдэхүүн

НҮ - Нийт үйлдвэрлэлт

ЗХ - Завсрын хэрэглээ

БЦТ - Бүтээгдэхүүний цэвэр татвар

ҮХЭ - Үндсэн хөрөнгийн элэгдэл

ӨААҮАББ - Өрхийн аж ахуйд үйлчилдэг ашгийн бус байгууллага

ЗГЧҮА - Засгийн газрын чиг үүргийн ангилал

ХХЗБҮА - Хувийн хэрэглээний зориулалттай бараа, үйлчилгээний ангилал

Нийтлэг үндэслэл

- Өөр хоорондоо харилцан уялдаатайгаар байгуулагдах макро эдийн засгийн цогц дансууд, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, ойлголт, тодорхойлолт, ангилал болон тооцооны арга зүйд үндэслэн зохиогдох тэнцэл, хүснэгт (нөөц, ашиглалтын хүснэгт, салбар хоорондын тэнцэл)-ээс Үндэсний тооцооны систем (ҮТС) бүрдэнэ.
- ҮТС-ийн гол цөм болох бараа, үйлчилгээний данс нь үндэсний тооцооны дансуудын эх буюу тэг данс гэж нэрлэгддэг бөгөөд эдийн засаг дахь бараа, үйлчилгээний урсгалыг харуулна.
- Үндэсний тооцооны дансанд тусгасан үзүүлэлт бүр эдийн засгийн тодорхой үйл ажиллагаа, утгыг илэрхийлж, нэг аж ахуйн нэгж, байгууллагын авсан, нөгөө аж ахуйн нэгж, байгууллагад өгсөн үйлдлийг харуулна. Үндэсний тооцооны данс нь нөөц ба ашиглалт гэсэн хоёр хэсгээс бүрдэх бөгөөд нөөц талд авсныг, ашиглалт талд өгснийг харуулна. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн үйл ажиллагааны өгөх, авах үйлдлийг дансны систем нэгэн зэрэг агуулна.
- Бараа, үйлчилгээний данс нь Үндэсний тооцооны системийн бараа, үйлчилгээний эрэлт, нийлүүлэлтийн тэнцлийг харуулдаг данс юм. Энэ нь бараа, үйлчилгээний нөөц, түүний ашиглалтыг бүтээгдэхүүн, үйлчилгээний бүлгээр болон нийт эдийн засгийн түвшинд мөн харуулж, нөөц, ашиглалтын хүснэгт, салбар хоорондын тэнцэл байгуулах үндсэн мэдээлэл болж өгнө.
- Бараа, үйлчилгээний дансны үзүүлэлтийн тооцох арга зүй нь ҮСХ-ны даргын 2008 оны 1/171 дугаар тушаалаар батлагдсан Үндэсний тооцооны дансууд байгуулах аргачлал, ҮСХ-ны даргын 2008 оны 01/174 дугаар тушаалаар батлагдсан Нөөц, ашиглалтын хүснэгт, салбар хоорондын тэнцэл зохиох аргачлал, ҮСХ, Сангийн сайд болон Гаалийн Ерөнхий Газрын даргын 2009 оны 2 дугаар сарын 17-ны 01/17/42/069 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан Гадаад худалдааны барааны статистик үзүүлэлтийг тооцох аргачлал, ҮСГ-ын даргын 2007 оны 101/2003 дугаар тушаалаар батлагдсан ДНБ болон Үндэсний орлого тооцох аргачлал болон Монголбанкны ерөнхийлөгч, ҮСХ-ны даргын 2009 оны 439/01/86 дугаар хамтарсан тушаалаар “Төлбөрийн тэнцлийг зохиох аргачлал”-уудад үндэслэнэ.

1. Ойлголт, тодорхойлолт

Бусдын хэрэгцээнд зориулан төлбөртэй үйлдвэрлэх, эсвэл үйлчилгээ үзүүлэх явдал бараа, үйлчилгээг үйл ажиллагааны хүрээний бусад хэлбэрээс зааглах шалгуур мөн бөгөөд ДНБ-ий голлох нэг хэсэг юм. Харин хувь хүн өөрөө хоол, ундаа хийх, хувцсаа угаах, орон гэрээ цэвэрлэх, усанд орох, гоо сайхны үйлчилгээ хийх зэрэг хүний ахуйн болон амьдралын хэв маягтай холбогдох хөдөлмөрийн үйл ажиллагааг ҮТС-д хамааруулдаггүй.

- **Үндсэн үнэ** гэж үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүнд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үзүүлсэн үйлчилгээг худалдан авагч үйлдвэрлэгчид төлөх ёстой үнээс тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлт, борлуулалтанд ногдуулах бүх төрлийн татварыг хасч, олгосон татаасыг нэмж тооцсон үнийн дүн юм.

- **Үйлдвэрлэгчийн үнэ.** Үндсэн үнэ дээр бүтээгдэхүүний борлуулалтад ногдуулах бараа, үйлчилгээний татваруудыг (нэмэгдсэн өртгийн албан татвар болон түүнтэй адилтгах бусад татвараас бусад) нэмж, татаасыг хасч тооцсон үнийг үйлдвэрлэгчийн үнэ гэнэ. Бараа, үйлчилгээг борлуулсны төлбөрийг (барааны үнийг) үйлдвэрлэгчийн үнээр хийх бөгөөд аж ахуйн нэгжүүд нэмэгдсэн өртгийн албан татварыг хассан үнээр өөрийнхөө борлуулалтын хэмжээг тодорхойлно.
- **Зах зээлийн буюу худалдан авагчийн үнэ.** Худалдан авагчийн үнэ нь худалдан авагчаас төлсөн мөнгөний дүн юм. Үйлдвэрлэгчийн үнэ дээр бүтээгдэхүүний борлуулалтад ногдуулдаг нэмэгдэл өртгийн албан татварыг нэмж тооцсон үнийг зах зээлийн буюу худалдан авагчийн үнэ гэнэ.
- **ФОБ нөхцлийн үнэ** (хил хүртэлх бүх зардлыг багтаасан) гэж СИФ үнээс экспортлогч (импортлогч) орны гаалийн хил болон импортлогч (экспортлогч) орны гаалийн хилийн хооронд гарах тээврийн зардал, даатгалын хураамжийг хассан үнийг хэлнэ.
- **СИФ нөхцлийн үнэ** гэж импортын татвар болон тухайн улсын доторхи худалдаа, тээврийн нэмэгдэл ногдуулахаас өмнөх, импортлогч улсын хил хүртэлх даатгал, ачаа тээврийн зардлыг ачуулсан барааны үнэд оруулсан, эсвэл эдийн засгийн харьяатад үзүүлсэн үйлчилгээний үнийг хэлнэ.
- **Эдийн засгийн харьяат** гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дээр оршин сууж байгаа Монгол улсын иргэд, гадаад оронд 1 жил хүртэлх хугацаагаар түр оршин сууж байгаа Монгол Улсын иргэд, Монгол улсын нутаг дэвсгэр дээр 1 жилээс дээш хугацаагаар оршин сууж байгаа гадаадын иргэд, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага, тэдгээрийн салбар, төлөөлөгчийн газар, Монгол Улсаас гадаад орнуудад суугаа элчин сайдын яам, консулын болон байнгын төлөөлөгчдийн газар, тэдгээрт ажилладаг Монгол Улсын иргэд, цэргийн албан хаагч гэр бүлийн гишүүдийн хамт, гадаад оронд сурч байгаа болон гадаадад урт, богино хугацаагаар эмчлүүлж байгаа Монгол Улсын иргэдийг хэлнэ.

2. Данс байгуулахад ашиглах ангилал

Бараа, үйлчилгээний данс байгуулахад дараах ангиллыг ашиглана. Үүнд:

- Нийт үйлдвэрлэлт, завсрын хэрэглээний зардлыг “Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн ангилал (СРС)”-ын дагуу ангилж, боловсруулалтыг хийнэ.
- Өрхийн аж ахуйн хэрэглээг “Хувийн хэрэглээний зориулалттай бараа, үйлчилгээний ангилал (СОICOP)”-ын дагуу ангилж, уг ангиллын нэр төрөл

бүрээр өрхийн хэрэглээг тооцож нөөц, ашиглалтын хүснэгтийн үзүүлэлтийн дагуу хөрвүүлнэ.

- Төрийн удирдлагын байгууллагын хэрэглээг тооцно. “Засгийн газрын чиг үүргийн олон улсын ангилал (COFOC)-ын дагуу боловсруулна.
- Бараа, үйлчилгээний экспорт, импортын гүйлгээг “Барааг кодлох, тодорхойлох уялдуулсан системийн ангилал (HS)”-ын дагуу боловсруулалтыг хийж, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн ангиллын дагуу хөрвүүлнэ.
- Хөрөнгийн нийт хуримтлалыг “Хөрөнгийн ангилал”-ын дагуу боловсруулалтыг хийж, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн ангиллын үзүүлэлтийн дагуу хөрвүүлнэ.

3. Бараа, үйлчилгээний данс, түүний үзүүлэлт

Бараа, үйлчилгээний данс нөөц ба ашиглалт гэсэн 2 хэсгээс бүрдэнэ. Нөөц нь үйлдвэрлэлт, импортоос; ашиглалт нь завсрын хэрэглээ, эцсийн хэрэглээ, нийт хуримтлал (үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал), экспортоос бүрдэнэ.

Бараа, үйлчилгээний дансанд ашиглалтыг баруун талд, нөөцийг зүүн талд тусгаж харуулдаг онцлогтой, өөрөөр хэлбэр, урсгал дансуудаас эсрэг байрлалд тусгана.

Бараа, үйлчилгээний дансанд баланслуулах үзүүлэлт байхгүй байна. Бараа, үйлчилгээний хураангуй дансыг хүснэгт 1.-ээр, дэлгэрэнгүй дансыг хавсралт 1-д үзүүлэв.

Хүснэгт 1.

Данс 0. Бараа, үйлчилгээний хураангуй данс

Нөөц	Ашиглалт
P.1 Нийт үйлдвэрлэлт	P.2 Завсрын хэрэглээ
P.7 Бараа, үйлчилгээний импорт	P.3/P.4 Эцсийн хэрэглээний зардал / жинхэнэ эцсийн хэрэглээ
D.21 Бүтээгдэхүүний татвар	P.5 Хөрөнгийн нийт хуримтлал
D.31 Бүтээгдэхүүний татаас (-)	P.51 Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал
	P.52 Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт
	P.53 Үнэт зүйлсийн хуримтлал
	P.6 Бараа, үйлчилгээний экспорт

3.1 Нийт үйлдвэрлэлт (P.1) гэж тайлант хугацаанд үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээний нийт хэмжээг хэлнэ.

Нийт үйлдвэрлэлтийг үндсэн үнээр бүртгэж, дараах 3 төрлийн үйлдвэрлэлтийг хамруулна. Үүнд:

- Зах зээлийн үйлдвэрлэлт
- Өөрийн хэрэглээнд зориулсан үйлдвэрлэлт
- Зах зээлийн бус бусад үйлдвэрлэлт

3.1.1 Зах зээлийн үйлдвэрлэлт (P.11)-д дараах бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг харуулна. Үүнд:

- Зах зээлд борлуулсан бүтээгдэхүүн
- Бараа солилцоогоор арилжсан бүтээгдэхүүн
- Биет байдлаар олгосон бүтээгдэхүүн (бэлэн бус хэлбэрээр ажиллагчдад биет (өөрөөр хэлбэл, мөнгөн биш) хэлбэрээр олгосон цалин, биет холимог орлого)
- Аж ахуйн нэгж, байгууллагын нэг салбар нэгж нь нөгөө салбар нэгжид бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн орц буюу завсрын хэрэглээнд эсвэл эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн
- Эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх болон дуусаагүй үйлдвэрлэлд (мал, амьтан болон газар тариалангийн өсөлтийг оруулаад) хамрах бүтээгдэхүүн зэрэг болно.

3.1.2 Өөрийн хэрэглээнд зориулсан үйлдвэрлэлт (P.12)-д өрх, аж ахуйн нэгж, байгууллагын эцсийн хэрэглээ эсвэл үндсэн хөрөнгийн нийт хуримтлалыг бий болгох зориулалттай өөрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үзүүлсэн үйлчилгээг хамруулна. Тухайлбал:

Эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээнд:

- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн
- Өөрөө эзэмшигч буюу өөрийн эзэмшлийн орон сууцны үйлчилгээ
- Өрхөд үйлчилсэн хөлсний ажилчны үйлчилгээ

Үндсэн хөрөнгийн нийт хуримтлалыг бий болгох зориулалттай бүтээгдэхүүн, үйлчилгээнд:

- Аж ахуйн нэгжийн өөрөө үйлдвэрлэсэн тусгай зориулалтын багаж, хэрэгсэл
- Өрхийн өөрийн хүчээр барьсан эсвэл өргөтгөж, шинэчилсэн орон сууц
- Аж ахуйн нэгж, байгууллагын өөртөө зориулж барьсан барилга

3.1.3 Зах зээлийн бус бусад үйлдвэрлэлт (P.13)-д эдийн засгийн ач холбогдолгүй үнэ, эсвэл бараг үнэгүй шахам нийлүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хамруулна.

3.2 Завсрын хэрэглээ (Р.2)-нд тухайн тайлант хугацаанд үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад орц байдлаар зарцуулсан бараа, үйлчилгээний материалын зардал болон үйлчилгээний төлбөрийг хамруулж тооцно. Хөрөнгө оруулалтын зардлыг завсрын хэрэглээнд оруулахгүй.

Завсрын хэрэглээний зардалд дараах бараа, үйлчилгээг мөн хамруулна. Үүнд:

а) Худалдан авалт, борлуулалт, зар сурталчилгаа, бүртгэл тооцоо, мэдээлэл боловсруулалт, тээвэр, агуулах, засвар үйлчилгээ, хамгаалалт зэрэг туслах үйл ажиллагаанд хэрэглэсэн бараа, үйлчилгээний зардал

б) Үндсэн хөрөнгийг түрээслэхтэй холбогдон гарах зардал, жишээлбэл, машин, тоног төхөөрөмж, автомашины үйл ажиллагааны лизингийн үйлчилгээ;

в) Ашгийн бус байгууллагад өгсөн хандив, төлсөн татвар, хураамжийн зардал;

г) Хөрөнгийн хуримтлалд тооцогдохгүй завсрын хэрэглээнд орох дараах эд зүйлс:

(1) Бага үнэтэй, ердийн хэрэглээнд зориулсан жижиг багаж хэрэгсэл: алх, хөрөө, хүрз, хутга, сүх, халив зэрэг бусад багаж; халаасны тооны машин зэрэг жижиг төхөөрөмж

(2) Үйлдвэрлэлийн явцад гарах үндсэн хөрөнгийн урсгал засвар үйлчилгээ

(3) Цэрэг, армийн эвдэрч, сүйдсэн зэвсэг (цагдаа, хүчний байгууллагын цэрэг армийн машин зэрэг нь нийт үндсэн хөрөнгийн хуримтлалд орно)

(4) Судалгаа, шинжилгээний ажил, ажиллагчдын сургалтын зардал, зах зээлийн судалгаа болон түүнтэй адил төстэй үйл ажиллагаа

д) Хөрөнгө эзэмшигчийн патент, худалдааны тэмдэг зэрэг биет бус үйлдвэрлэгдэхгүй хөрөнгийг ашигласны төлбөр (Өмчийн эрхийг худалдан авахтай холбогдолтой зардлыг оруулахгүй.);

е) Багаж хэрэгсэл, ажлын хувцас зэрэг үйлдвэрлэлийг явуулахад шаардлагатай эд зүйлсийг худалдан авахтай холбогдон гарах зардал;

ё) Үйлдвэрлэл, үйлчилгээг явуулахад ажил олгогчоос ажиллагчдад олгосон зардал, тухайлбал:

(1) Ажиллагчдын унаа, зочид буудал, томилолтын зардал, тэднийг үүрэгт ажлаа гүйцэтгэхтэй холбогдон гарсан зардал, шилжүүлэхтэй холбогдон гарах зардал, хүлээн авалтын зардал

(2) Ажлын байрны тав тухыг хангахтай холбогдон гарах зардал

з) Амь насны даатгалаас бусад даатгалын төлбөр;

ж) Эдийн засгийн харьяат үйлдвэрлэгчийн санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээ;

и) Санхүүгийн үйлчилгээний байгууллагын завсрын хэрэглээнд тусгагдах Монголбанкны бүтээгдэхүүн, үйлчилгээ

Завсрын хэрэглээний зардалд дараах бүтээгдэхүүн, үйлчилгээ орохгүй.
Үүнд:

а) Хөрөнгийн хуримтлалд орж тооцогдох зүйлс:

- (1) Үнэт зүйлс
- (2) Ашигт малтмалын хайгуулын ажил
- (3) Үндсэн хөрөнгийг сэргээн засварлах, сайжруулах, их засвар хийх, өргөтгөх зардал
- (4) Программ хангамж худалдан авах зардал

б) Ажиллагчдад мөнгөөр болон мөнгөн бус хэлбэрээр олгосон цалин, түүнтэй адилтгах орлого

в) Төрийн байгууллагын нийтлэг үйлчилгээний зардал (төрийн байгууллагын хамтын хэрэглээний зардалд оруулж тооцно);

г) Засгийн газарт төлсөн лизенц, төлбөр (үйлдвэрлэлийн татварт оруулж тооцно).

3.3 Эцсийн хэрэглээ (P.3, P4)-г эцсийн хэрэглээний зардал (P.3) болон эцсийн жинхэнэ хэрэглээ (P.4) гэж ангилна.

Эдийн засгийн секторуудын бараа, үйлчилгээний зардал нь эцсийн хэрэглээний зардал болно. Бараа, үйлчилгээний хэрэглээний зардал нь эцсийн жинхэнэ хэрэглээ байна. Зарим бараа, үйлчилгээний зардлыг Засгийн газар болон өрхийн аж ахуйд үйлчилдэг ашгийн бус байгууллагаар санхүүжүүлж, өрхөд биет хэлбэрийн нийгмийн халамжийн тэтгэмжээр дамжуулан хийх үед дээрх хоёр үзүүлэлтийн ойлголтын ялгаа харагдана.

3.3.1 Эцсийн хэрэглээний зардал (P.3) нь эдийн засгийн харьяат секторуудын хувийн болон хамтын хэрэглээнд зориулсан бараа, үйлчилгээний зардал байна. Эцсийн хэрэглээний зардлыг дотоодод болон гадаад оронд гаргаж болно.

3.3.1.1 Өрхийн эцсийн хэрэглээний зардалд дараах бараа, үйлчилгээг хамруулна. Үүнд:

а) Өөрийн эзэмшлийн орон сууны үйлчилгээ

б) Бэлэн бус орлого:

- (1) ажиллагчдын орлого хэлбэрээр авсан бараа, үйлчилгээ
- (2) өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ. Тухайлбал, хүнсний болон хөдөө аж ахуйн бараа, өөрийн эзэмшлийн байр, орон сууц, өрхийн хувийн орон сууцны үйлчилгээ болон өрхийн үйлчилгээ (үйлчлэгч, тогооч, цэцэрлэгч, жолооч зэрэг) хамаарна.

в) Завсрын хэрэглээнд оруулж тооцохгүй бараа, үйлчилгээ:

- (1) Түрээслэгч (түрээсээр авагч)-ийн болон эзэмшигчээс сууцандаа хийсэн жижиг хэмжээний засвар, дотоод заслын материал
 - (2) Хувийн хэрэглээний удаан эдэлгээт бараа (тээврийн хэрэгслийг оруулаад)-ны засвар, үйлчилгээний материал
- г) Аж ахуйн нэгжээс өрхөд ашиглуулсан хувийн хэрэглээний зарим удаан эдэлгээт барааны өмчлөх эрхийг шилжүүлэх зэрэг хөрөнгийн хуримтлалд оруулахгүй зардал
- д) Өрхийн эцсийн хэрэглээний зардалд хамаарах санхүүгийн байгууллагын шууд бус үйлчилгээ болон шууд төлсөн санхүүгийн үйлчилгээ
- е) Даатгалын үйлчилгээний шууд бус төлбөр, хураамж
- ё) Тэтгэврийн сангийн шууд бус төлбөр, хураамж
- ж) Үйлчилгээний худалдан авалт хэлбэрээр хийгдсэн өрхийн бүтээгдэхүүн, үйлчилгээний зөвшөөрөл, лицензийн төлбөр
- з) Музейн тасалбар зэрэг бага үнэтэй бараа, үйлчилгээний худалдан авалт

Эцсийн хэрэглээний зардалд дараах бараа, үйлчилгээг оруулахгүй. Үүнд:

- а) Өрхийн хэрэглээний зардал хэлбэрээр нийгмийн даатгалаас санхүүжих нийгмийн буцалтгүй шилжүүлэг (эмчилгээний зардлын тодорхой хэсэг)
- б) Завсрын хэрэглээ, эсвэл хөрөнгийн нийт хуримтлалд оруулж бүртгэх зүйлс:
 - (1) Арилжааны зорилготой байгуулсан хоршоолоогүй өрхийн аж ахуйн зардал. Тухайлбал, тээврийн хэрэгсэл, тавилга эсвэл цахилгаан хэрэгсэл (үндсэн хөрөнгийн хуримтлал) зэрэг удаан эдэлгээт бараа болон түлш, шатахуун (завсрын хэрэглээний зардал).
 - (2) Өөрийн эзэмшлийн байр, орон сууцны засвар, үйлчилгээ, дотоод засал (орон сууцны үйлчилгээг завсрын хэрэглээний зардалд оруулна)-ын зардал
 - (3) Барилга, орон сууц худалдан авах зардал (хөрөнгийн нийт хуримтлалд орно)
 - (4) Үнэт зүйлсийн зардал (хөрөнгийн нийт хуримтлалд орно)
- в) Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгийн өөрчлөлт, ялангуяа газар худалдан авах зардал
- г) Өрхийн төлж буй бүх төрлийн татвар, хураамж (тээврийн хэрэгсэл, завь эсвэл нисдэг тэрэг эзэмшигчийн лицензийн

татвар, мөн ан агнуур хийх, загас агнах зөвшөөрлийн бичгийн хураамжийн зардал)

д) Мэргэжлийн холбоо, хэрэглэгчдийн нийгэмлэг, шашин, сүм, хийд болон нийгэм, соёл, амралт, спортын клуб, нийгэмлэг зэрэг өрхийн аж ахуйд үйлчилдэг ашгийн бус байгууллагад өрхөөс нийлүүлж байгаа гишүүнчлэлийн хандив, төлж буй татвар, хураамж

е) Өглөг буян, тусламжийн байгууллагад нийлүүлсэн сайн дурын бэлэн, бэлэн бус шилжүүлэг

3.3.1.2 Өрхийн аж ахуйд үйлчилдэг ашгийн бус байгууллагын эцсийн хэрэглээний зардлыг хоёр ангилна. Үүнд:

а) Өрхийн аж ахуйд үйлчилдэг ашгийн бус байгууллагын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үзүүлсэн үйлчилгээ

б) Зах зээлд зориулж үйлдвэрлэсэн бараа, үзүүлсэн үйлчилгээг ямар нэгэн боловсруулалт ӨААҮАББ-аас хийхгүйгээр өрхийн хэрэглээнд олгосон нийгмийн бэлэн бус шилжүүлэг

3.3.1.3 Төрийн байгууллагын эцсийн хэрэглээг өрхийн аж ахуйд үйлчилдэг ашгийн бус байгууллагатай адил 2 ангилна. Үүнд:

а) Төрийн байгууллагын үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээ (өөрийн бий болгосон хөрөнгийн хуримтлал (P.12) болон борлуулалтаас бусад). Зах зээлийн үйлдвэрлэлт (P.11) болон зах зээлийн бус үйлдвэрлэлт (P.131) байна;

б) Биет хэлбэрийн нийгмийн халамжийн тэтгэмж /Нийгмийн халамжийн тусламж, нөхөн олговор (D.6311) + зах зээлийн үйлдвэрлэгчдээс биет хэлбэрээр олгосон бусад халамжийн тэтгэмж (D.63121) + зах зээлийн үйлдвэрлэгчийн нийгмийн халамжийн тусламж (D.63131)/ хэлбэрээр зах зээлийн үйлдвэрлэгчдээс Засгийн газрын худалдан авч өрхөд нийлүүлсэн бараа, үйлчилгээ (бараа, үйлчилгээг хувиргахгүйгээр шууд).

3.3.2 Эцсийн жинхэнэ хэрэглээ (P.4) гэж хувийн эсвэл хамтын хэрэгцээг хангахад чиглэгдсэн эдийн засгийн харьяат нэгжүүдийн үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээг энд хамруулна.

Төрийн удирдлагын байгууллагаас үзүүлж буй бараа, үйлчилгээг Засгийн чиг үүргийн ангилал (ЗГЧҮА)-ын дагуу хувийн болон хамтын хэрэглээний зардалд хуваарилна.

3.3.2.1 Хувийн хэрэглээнд зориулсан бараа, үйлчилгээ нь өрх, түүний гишүүдийн хэрэгцээг хангаж чадахуйц өрхийн хэрэглээний зардал юм.

Өрхийн эцсийн хэрэглээний бүх зардал нь хувийн хэрэглээний зардал байна. Өрхийн аж ахуйд үйлчилдэг ашгийн бус байгууллагын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үзүүлсэн үйлчилгээ нь хувийн хэрэглээний зардалд хамаарна.

Олон улсын валютын сангаас боловсруулсан Засгийн газрын санхүүгийн статистикийг боловсруулах гарын авлагад тусгагдсан ЗГЧҮА-ын дагуу дараах зардлыг хувийн хэрэглээний зардалд хамруулна. Үүнд:

1. Эрүүл мэндийн үйлчилгээ буюу ЗГЧҮА-ын 7-р салбарт хамаарах:
 - 7.1 Эмнэлгийн бүтээгдэхүүн, эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл
 - 7.2 Амбулаторийн үйлчилгээ
 - 7.3 Эмнэлгийн үйлчилгээ
 - 7.4 Эрүүл мэндийн үйлчилгээ
2. Амралт, чөлөөт цаг болон сүм, хийдийн үйлчилгээ буюу ангиллын 8-р салбарт хамаарах:
 - 8.1 Амралт чөлөөт цаг, спортын үйлчилгээ
 - 8.2 Соёлын үйлчилгээ
3. Боловсролын үйлчилгээ буюу 9-р салбарт хамаарах:
 - 9.1 Сургуулийн өмнөх болон анхан шатны боловсролын үйлчилгээ
 - 9.2 Дунд боловсролын үйлчилгээ
 - 9.3 Тусгай дунд мэргэжлийн боловсролын үйлчилгээ
 - 9.4 Дээд боловсролын үйлчилгээ
 - 9.5 Түвшнийг нь тодорхойлох боломжгүй боловсролын үйлчилгээ
 - 9.6 Боловсролын туслах үйлчилгээ
4. Нийгмийн хамгааллын үйлчилгээ буюу ангиллын 10-р салбарт хамаарах:
 - 10.1 Өвчин эмгэг болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ
 - 10.2 Өндөр настанд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ
 - 10.3 Гамшгаас амьд үлдэгсдэд зориулсан нийгмийн халамжийн үйлчилгээ
 - 10.4 Гэр бүл, хүүхдэд үзүүлэх халамжийн үйлчилгээ
 - 10.5 Ажилгүй иргэдэд олгох тэтгэмж
 - 10.6 Орон сууцны дэмжлэг үзүүлэх үйлчилгээ
 - 10.7 Нийгмээс тусгаарлагдсан иргэдэд үзүүлэх үйлчилгээ

Мөн төрийн байгууллагаас өрхийн хувийн хэрэглээнд зориулан зарцуулсан зардал нь хувийн хэрэглээний зориулалттай бараа, үйлчилгээний ангилал (ХХБҮА)-ын 14 дүгээр салбарын буюу төрийн удирдлагын байгууллагын хувийн хэрэглээний зардлын үзүүлэлттэй ижил байна. Тухайлбал:

14.1 Орон сууцны үйлчилгээ (ЗГЧҮА-ын 10.6-тай тохирно.)

14.2 Эрүүл мэндийн үйлчилгээ (ЗГЧҮА-ын 7.1 - 7.4)

14.3 Амралт чөлөөт цаг, соёл урлагийн үйлчилгээ (ЗГЧҮА-ын 8.1 – 8.2)

14.4 Боловсролын үйлчилгээ (ЗГЧҮА-ын 9.1 – 9.6)

14.5 Нийгмийн хамгааллын үйлчилгээ (ЗГЧҮА-ын 10.1 - 10.5 болон 10.7)

3.3.2.2 Хамтын хэрэглээнд зориулсан үйлчилгээ нь өрх болон хэсэг бүлэг хүмүүсийн хэрэгцээг хангахад чиглэгдсэн үйлчилгээ байна.

Хамтын хэрэглээний зардал нь төрийн байгууллагын эцсийн хэрэглээний зардлын буюу ЗГЧҮА-ны дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. Нийтийн ерөнхий үйлчилгээ
2. Батлан хамгаалах үйл ажиллагаа
3. Нийгмийн хэв журам, аюулгүй байдлын үйл ажиллагаа
4. Эдийн засгийн үйл ажиллагаа
5. Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа
6. Орон сууц, нийтийн аж ахуйн үйл ажиллагаа
7. Төрийн удирдлага, зохицуулалт, ерөнхий болон статистикийн мэдээллийн тархаалтын үйл ажиллагаа
8. Судалгаа, шинжилгээ ба хөгжлийн асуудал

Дараах хүснэгтээр дээр дурьдсан ойлголтын уялдааг харуулав.

	Эдийн засгийн сектор			
	Төрийн байгууллага	Өрхийн аж ахуйд үйлчилдэг ашгийн бус байгууллага	Өрх	Нийт хэрэглээ
Хувийн хэрэглээ	X (= биет хэлбэрийн нийгмийн халамж)	X (= биет хэлбэрийн нийгмийн халамж)	X	Өрхийн хувийн эцсийн жинхэнэ хэрэглээ
Хамтын хэрэглээ	X	0	0	Төрийн байгууллагын хамтын эцсийн

				жинхэнэ хэрэглээ
Бүгд	Төрийн байгууллагын эцсийн хэрэглээний зардал	Өрхийн аж ахуйд үйлчилдэг ашгийн бус байгууллагын эцсийн хэрэглээний зардал	Өрхийн эцсийн хэрэглээний зардал	Эцсийн жинхэнэ нийт хэрэглээ = Эцсийн нийт хэрэглээний зардал

x – хамааралтай
0 - хамааралгүй

Өрхийн аж ахуйд үйлчилдэг ашгийн бус байгууллагын эцсийн хэрэглээний зардал нь бүхэлдээ хувийнх байна. Иймээс өрхийн эцсийн жинхэнэ хэрэглээний зардал, төрийн байгууллагын эцсийн жинхэнэ хэрэглээний зардлаас эцсийн жинхэнэ хэрэглээний нийт зардал бүрдэнэ.

3.4 Хөрөнгийн нийт хуримтлал (P.5) дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

- а) Үндсэн хөрөнгийн хуримтлал (P.51)
- б) Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт (P.52)
- в) Үнэт зүйлсийн хуримтлал (P.53)

Хөрөнгийн нийт хуримтлал нь үндсэн хөрөнгийн хэрэглээний дүнг багтаасан байдаг бол хөрөнгийн цэвэр хуримтлал нь үндсэн хөрөнгийн нийт хуримтлалаас үндсэн хөрөнгийн хэрэглээг хассан дүн байна.

3.4.1 Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал (P.51) нь тайлант хугацааны эдийн засгийн харьяат үйлдвэрлэгчдийн эзэмшсэн үндсэн хөрөнгөөс хасагдсан үндсэн хөрөнгийг хасч, аж ахуйн нэгж, байгууллагын бий болгосон үйлдвэрлэгдэхгүй хөрөнгийн дүнгийн нийлбэр байна.

Үндсэн хөрөнгийн хуримтлалын нэмэгдэх, хасагдах үзүүлэлтийг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

- 1) Нэмэгдэх үндсэн хөрөнгө:
 - 1.1 Худалдаж авсан шинэ эсвэл хуучин үндсэн хөрөнгө
 - 1.2 Өөрийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэгчийн үйлдвэрлэсэн үндсэн хөрөнгө
 - 1.3 Бараа солилцоогоор авсан шинэ, хуучин үндсэн хөрөнгө
 - 1.4 Хөрөнгийн шилжүүлэг хэлбэрээр авсан шинэ, хуучин үндсэн хөрөнгө
 - 1.5 Санхүүгийн лизингээр эзэмшсэн шинэ, хуучин үндсэн хөрөнгө
 - 1.6 Үндсэн хөрөнгө болон түүхийн дурсгалт хөшөө зэрэгт хийгдсэн өргөтгөл, шинэчлэлийн ажил
 - 1.7 Өсгөж, үржүүлдэг хөрөнгийн өсөлт
- 2) Хасагдах үндсэн хөрөнгө:

- 2.1 Худалдсан
- 2.2 Бараа, солилцоогоор арилжсан
- 2.3 Бэлэн бус шилжүүлгээр мөн арилжсан.

Үндсэн хөрөнгийн хуримтлалыг дараах төрөлд ангилж авч үзнэ.
Үүнд:

- 1) Биет үндсэн хөрөнгө
 - 1.1 Орон сууцны барилга
 - 1.2 Бусад барилга, байгууламж
 - 1.3 Машин, тоног төхөөрөмж
 - 1.4 Өсөж үрждэг хөрөнгө (ургамал, мал, амьтан зэрэг)
- 2) Биет бус үндсэн хөрөнгө
 - 2.1 Геологи хайгуул, зураг төслийн ажил
 - 2.2 Компьютерийн программ хангамж
 - 2.3 Үзмэр, утга зохиол, урлаг, уран сайхны эх бүтээл
 - 2.4 Биет бус бусад хөрөнгө
- 3) Үйлдвэрлэгдэхгүй биет хөрөнгөд хийсэн өргөтгөл шинэчлэл, ялангуяа газарт хамаарах хэсэг (гэхдээ, үйлдвэрлэгдэхгүй хөрөнгийн эзэмшлийг оруулахгүй). Газарт хийсэн шинэчлэлийн ажилд дараах ажил үйлчилгээ оруулна. Тухайлбал:
 - 1) Усны суваг, шуудуу, далан зэргийг барих зорилготой газрын хөрс сайжруулалтын ажил
 - 2) Үйлдвэрлэлд газрыг ашиглах боломжийг бүрдүүлэх зорилгоор ой, хад чулууг цэвэрлэх ажил
 - 3) Усны суваг, шуудуу, далан барих зорилгоор цөлийг усжуулах, намгийг хатаах зэрэг ажил
- 4) Газар, патент зэрэг үйлдвэрлэгдэхгүй хөрөнгийг эзэмших эрхийг шилжүүлэхтэй холбогдон гарах зардал

Үндсэн хөрөнгийн хуримтлалд дараах хөрөнгийн хуримтлалыг хамруулна. Үүнд:

- 1) Хүн амьдрах зориулалтаар ашиглагдах зөөврийн байшин, унтлагын завь, усан онгоц,
- 2) Иргэний инженерийн байгууламжтай адил төстэй цэргийн зориулалттай инженерийн байгууламж болон тоног төхөөрөмж (нисэх талбай, усан онгоцны зогсоол, эмнэлэг, зам зэрэг)
- 3) Цэрэг, армийн бус зориулалтаар ашиглагдах зэвсэг болон тээврийн хэрэгсэл
- 4) Үржил, мах, сүү, ноосны чиглэлийн мал, амьтан болон ажлын мал зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах малын тооны өөрчлөлт
- 5) Жимс хурааж авах зориулалтаар үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд давтан ашиглагдах мод, бут, суулгацын тооны өөрчлөлт
- 6) Хуучин үндсэн хөрөнгийг өргөтгөх ажил
- 7) Лизингээр авсан үндсэн хөрөнгийн хуримтлал

Үндсэн хөрөнгийн хуримтлалд дараах хөрөнгийг хамруулахгүй.
Үүнд:

1. Завсрын хэрэглээний зардалд орох ажил гүйлгээ:
 - 1.1 Үйлдвэрлэлд ашиглагдах жижиг багаж, хэрэгсэл
 - 1.2 Тогтмол хийгддэг засвар үйлчилгээ
 - 1.3 Цэргийн зэвсэг түүний дагалдах хэрэгслийн худалдан авалт
 - 1.4 Лизингээр худалдан авсан үндсэн хөрөнгө
2. Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтөнд тооцогдох ажил гүйлгээ:
 - 2.1 Мах, сүүний чиглэлийн мал, амьтан
 - 2.2 Мод бэлтгэлийн зориулалтаар тарьж ургуулж буй мод (дуусаагүй үйлдвэрлэлд орно)
 - 2.3 Эцсийн хэрэглээнд зориулсан өрхийн эзэмшдэг машин, тоног төхөөрөмж (өрхийн эцсийн хэрэглээний зардал)
 - 2.4 Үндсэн хөрөнгө эзэмшлийн ашиг, алдагдал (хөрөнгийн бусад өөрчлөлт)
 - 2.5 Өсөж үрждэг хөрөнгийн хорогдол (даатгалд хамрагдаагүй), үер, ус, салхи, шуурганы аюул эсвэл ойн түймэр зэрэг ослын шалтгаанаар үүссэн хөрөнгийн бусад өөрчлөлт)

Биет бус үндсэн хөрөнгөд дараах хөрөнгийн хамруулна. Үүнд:

1. Ашигт малтмалын хайгуулын өрөмдлөгийн зардал, агаарын тандалт эсвэл бусад судалгаа болон тээврийн зардал
2. Үйлдвэрлэлд нэг жилээс дээш хугацаагаар ашиглах компьютерын програм хангамж, том хэмжээний мэдээллийн сан
3. Эх бичмэл, бичлэг, загвар, кино, дуу бичлэг зэрэг урлаг, утга зохиолын эх бүтээл

Үндсэн хөрөнгө болон санхүүгийн бус үйлдвэрлэгдэхгүй хөрөнгийн эзэмших эрхийг шилжүүлэхтэй холбогдон гарах зардалд дараах ажил гүйлгээг оруулна. Үүнд:

1. Тээврийн зардал, суурилуулах зардал, угсрах зардал зэрэг хөрөнгийг (шинэ эсвэл хуучин хөрөнгө) нийлүүлж хүргэхтэй холбогдон гарах зардал
2. Хяналтын байцаагч, инженер, хуульч, үнэлээч зэрэг мэргэжлийн хүмүүст төлөх хураамж, татвар болон хөрөнгийн агент, дуудлага худалдаачин зэрэгт төлөх хураамж
3. Хөрөнгийг өмчлөх эрхийг шүлжүүлэхтэй холбогдон гарах шинэ өмчлөгчийн хөрөнгийн татвар

3.4.2 Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт (P.52).

Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийг тухайн жилд нэмж эзэмшсэн болон хасагдсан материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн зөрүүгээр тодорхойлно.

Материаллаг эргэлтийн хөрөнгийн биет хэмжээнд чанарын өөрчлөлт гарах, эсвэл гэнэтийн тохиолдлоор гэмтэх, хулгайд алдах зэрэг аж ахуйн нэгжийн дотоод үйл ажиллагаанаас үүдэлтэйгээр материаллаг эргэлтийн хөрөнгө хорогдож болно.

Материаллаг эргэлтийн хөрөнгө дараах бүтэцтэй байна. Үүнд:

1. Түүхий эд, үндсэн материал үйлдвэрлэлийн явуулахад завсрын хэрэглээнд ашиглах зорилгоор худалдаж авсан бүх төрлийн бараа, бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Үйлдвэрлэгчийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд алт, алмааз зэрэг үнэт чулуу завсрын хэрэглээ болох тохиолдолд эдгээр зүйлсийг материаллаг эргэлтийн хөрөнгө байдлаар бүртгэнэ. Бусад тохиолдолд үнэт зүйлсийн хуримтлалд орно.

2. Дуусаагүй үйлдвэрлэл: Үйлдвэрлэлийн ямар нэгэн үе шатанд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь дуусаагүй байвал түүнийг дуусаагүй үйлдвэрлэл гэнэ. Дуусаагүй үйлдвэрлэл эдийн засгийн аль ч салбарт гарч болно. Тухайлбал:

- (1) Үр тариа ургуулах
- (2) Мод ургуулах, мал, амьтан өсгөх
- (3) Барьж дуусаагүй байгууламж (гэрээгээр урьдчилан борлуулахаар тохирсон болон өөрийн хэрэглээнд зориулж өөртөө үйлдвэрлэсэн үндсэн хөрөнгийн хуримтлалд тооцогдох хөрөнгөнөөс бусад)
- (4) Дуусаагүй бусад үндсэн хөрөнгө
- (5) Хуулийн эсвэл зөвлөхийн хэсэгчлэн дууссан хавтаст хэрэг
- (6) Хэсэгчлэн дууссан кино үйлдвэрлэл
- (7) Хэсэгчлэн дууссан програм хангамжийн үйлдвэрлэл.

Үйлдвэрлэлийн дуусаагүй үйл ажиллагааг нь дууссан тохиолдолд дуусаагүй үйлдвэрлэлийн хэмжээ буурч, бэлэн бүтээгдэхүүний хэмжээ өснө.

Өсөж үрждэг хөрөнгийн дуусаагүй үйлдвэрлэл

Эдийн засгийн нэгжийн шууд хяналтанд байдаг мал аж ахуй, газар тариалангийн байгалийн өсөлт, үржилтийн ажиллагаа үндэсний тооцооны системийн эдийн засгийн үйл ажиллагаанд орно. Энэхүү эдийн засгийн үйл ажиллагааг нэг удаа (модыг ургаж гүйцсэн хойно нь тайрч огтлох зорилгоор тарих, малыг нядалгааны зорилгоор өсгөх зэрэг) хэрэглэх суулгац, мод, мал, амьтан эсвэл үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд олон удаа (үр жимсийг нь авч байх зорилгоор жимсний мод тарих, сүү, ноос, ноолуурыг нь авч ашиглах зорилгоор малыг өсгөж үржүүлэх зэрэг) хэрэглэх суулгац, мод, мал, амьтны аль байгааг ялгаж тодорхойлох нь их чухал бөгөөд энэ хоёр тохиолдолд аль алинд нь дуусаагүй үйлдвэрлэлийн бичилт хийнэ.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нэг удаа хэрэглэх суулгац, мод, мал, амьтан тухайлбал, ургаж гүйцсэн хойно нь тайрч огтлох зорилгоор тарьж ургуулсан мод эсвэл нядалгааны зорилгоор өсгөсөн малыг тайлант хугацааны эцэст огтлоогүй, нядлаагүй тохиолдолд энэ нь дуусаагүй үйлдвэрлэл болно.

Бусад үндсэн хөрөнгийн дуусаагүй үйлдвэрлэл

Барилга, байгууламж болон бусад үндсэн хөрөнгөнд эцсийн бүтээгдэхүүн болтол нилээд урт хугацаа зарцуулдаг. Энэ

тохиолдолд тайлант хугацаанд бүрэн гүйцэт дуусаагүй үндсэн хөрөнгө нь тухайн хөрөнгийг барьж байгуулж байгаа үйлдвэрлэгчийн тайлант хугацаанд дахь дуусаагүй үйлдвэрлэл болно. Өөрөө үйлдвэрлээд өөртөө хэрэглэх зорилгоор үйлдвэрлэж байгаа болон урьдчилан байгуулсан худалдааны гэрээний үндсэн дээр үйлдвэрлэсэн үндсэн хөрөнгө нь тэдний эцсийн хэрэглэгчийн эзэмшилд шууд очиж үндсэн хөрөнгө болох учраас түүнийг дуусаагүй үйлдвэрлэлд оруулахгүй.

3. Бэлэн бүтээгдэхүүн. Бэлэн бүтээгдэхүүн гэж үйлдвэрлэлийн бүх явцыг бүрэн дуусгаж, хэрэглэгчдэд нийлүүлэхэд бэлэн болсон бүтээгдэхүүнийг хэлнэ. Тухайн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийнхээ хувьд бэлэн бүтээгдэхүүн, харин бусад үйлдвэрлэгчийн хувьд завсрын хэрэглээ байж болно.
4. Дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүн. Бөөний болон жижиглэн худалдааны байгууллагуудад байгаа хэрэглэгчдэд худалдах зориулалттай бараа, бүтээгдэхүүн юм.

3.4.3 Үнэт зүйлсийн хуримтлал (P.53). Үнэт зүйлс нь үйлдвэрлэлийн болон хэрэглээний зориулалтгүй, элэгдэж хорогддоггүй онцлогтой. Өөрөөр хэлбэл, үнэт зүйлс нь цаг хугацааны явцад хэрэглээний чанар эсвэл бодит үнэ цэнээ алдаггүй үнэ нь улам нэмэгддэг зүйлс орно. Үнэт зүйлсийг дараах төрөлд хуваана. Үүнд:

1. Аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа завсрын хэрэглээ байдлаар ашиглах зорилгогүйгээр олж эзэмшсэн үнэт металл, чулуу тухайлбал, алмаз, мөнгөжөөгүй алт, платин, мөнгө.
2. Уран зураг, баримал зэрэг урлагийн бүтээл гэж тооцогддог зүйлс
3. Үнэт металл, чулуугаар хийсэн үнэт эдлэл, цуглуулга зэрэг бусад үнэт зүйлс.

Үнэт зүйлсийн хуримтлалыг дараах тохиолдолд бүртгэнэ. Үүнд:

1. Монгол банк болон бусад санхүүгийн зуучлалын байгууллагын мөнгөжөөгүй алт, мөнгө зэргийг олж эзэмших эсвэл эзэмшлээс хасах гүйлгээ;
2. Аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэлийн завсрын хэрэглээ, үндсэн хөрөнгийн хуримтлалд бүртгэгдээгүй үнэт зүйлсийг эзэмших эсвэл хасах гүйлгээ;
3. Өрхийн эцсийн хэрэглээ хэлбэрээр бүртгэгдээгүй өрхийн үнэт зүйлсийг эзэмших эсвэл хасах гүйлгээ.

3.5 Бараа, үйлчилгээний экспорт, импорт (P.6, P.7) нь эдийн засгийн харьяат болон харьяат бусын хооронд хийгдэх бараа, үйлчилгээний экспорт (борлуулалт, бараа солилцоо, бэлэг эсвэл тусламж), импорт (худалдан авалт, бараа солилцоо, бэлэг эсвэл тусламж)-оос бүрдэнэ.

3.5.1 Барааны экспорт, импорт (P.61, P.71). Эдийн засгийн харьяат, харьяат бусын хооронд хийсэн барааны экспорт, импортыг энд бүртгэнэ.

Экспорт, импортод дараах төрлийн барааг бүртгэнэ. Үүнд:

1. мөнгөжөөгүй алт;
2. гүйлгээнд ороогүй мөнгөн тэмдэгт, зоос, үнэт цаас;
3. Засгийн газрын худалдааны хэлэлцээр, гадаад тусламжийн хөтөлбөр болон дайны нөхөн төлбөрийн дагуу эдийн засгийн нутаг дэвсгэрт оруулж, түүнээс гаргаж байгаа иргэний болон цэргийн зориулалттай бараа /төлбөр, хандив, зээл, солилцооны бараа хамаарна/;
4. хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжийн бараа;
5. хөрөнгө оруулалтын бараа;
6. цэргийн зориулалттай бараа;
7. зорчигчийн арилжааны шинж чанартай бараа;
8. консигнацийн бараа /улсын хил нэвтрэх үед өмчлөлийн эрх шилжээгүй, арилжих зорилго бүхий бараа, тухайлбал үзэсгэлэн, яармагт тавигдаж буй бараа/;
9. арилжааны зориулалттай програм хангамж, бичлэг хийгдсэн аудио, видео хальс;
10. толгой компани болон түүний шууд хөрөнгө оруулалтаар бий болсон охин компаний хооронд шилжүүлж буй бараа;
11. цахилгаан эрчим хүч, хий, ус;
12. улс хоорондын шуудан илгээмжийн арилжааны шинж чанартай бараа;
13. шилжин суурьшигчдын үнэ бүхий эд хогшил;
14. нэг ба түүнээс дээш жилээр түрээслэх бараа;
15. хоосон лонх, сав, баглаа, боодол;
16. тодорхой үнэ өртөг бүхий үйлдвэрлэлийн хаягдал, үлдэгдэл /тухайлбал, хаягдал лааз, хүнсний үйлдвэрлэлээс гарсан үлдэгдэл, хаягдал зэрэг/, аюултай хог хаягдал;
17. усан онгоц, агаарын болон бусад тээврийн хэрэгсэл;
18. Монгол улсын нутаг дэвсгэрт гадаадын нисэх онгоцонд олгосон түлш, шатахуун, хүнс болон бусад эд зүйл;
19. Монгол улсын нутаг дэвсгэрт гадаадын нисэх онгоцноос дотоодын нисэх онгоцонд олгосон түлш, шатахуун, хүнс, бусад эд зүйл болон гадаадын нисэх онгоцноос дотоодын нисэх буудалд буулгасан бараа.

Экспорт, импортын тооцоонд оруулахгүй бараа:

1. мөнгөжсөн алт;
2. гүйлгээнд оруулсан мөнгөн дэвсгэрт, зоос, үнэт цаас /үүнд гадаад валютын зузаатгал орно/;
3. хилийн чанадад 1 жилээс дээшгүй хугацаагаар гаргасан, гаалийн нутаг дэвсгэрт 1 жилээс дээшгүй хугацаагаар оруулсан бараа;
4. улс хооронд дамжуулан өнгөрүүлэх бараа;
5. захиалгын сонин, тогтмол хэвлэл;
6. захиалгын дагуу хийгдсэн програм хангамж, түүнийг агуулж байгаа диск, эх бичлэг хийгдсэн аудио болон видео хальс; захиалгаар хийгдсэн зураг төсөл;
8. нэг жилээс дээшгүй хугацаагаар түрээслэх бараа;

9. устгах бараа;
10. дахин ашиглагдах эргэлтийн хоосон лонх, сав, баглаа, боодол;

3.5.2 Үйлчилгээний экспорт, импорт (P.62, P.72). Эдийн засгийн харьяат, харьяат бусын хооронд хийсэн экспорт, импортын үйлчилгээг энд бүртгэнэ.

Үйлчилгээний импорт нь эдийн засгийн харьяатын шууд худалдан авсан үйлчилгээ байна. Бизнес эсвэл хувийн аяллын зорилгоос хамааран бизнесийн, хувийн аялал гэж ангилна. Бизнес аяллын зардал нь завсрын хэрэглээнд, харин хувийн аяллын зардал нь өрхийн эцсийн хэрэглээнд орно.

3.6 Бүтээгдэхүүний татвар (D.21) нь улсын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэлд тусгагдсан бараа, ажил, үйлчилгээнд ногдуулсан татварын дүн байна. Өөрөөр хэлбэл, үйлдвэрлэгчээс үйлдвэрлэсэн, ачуулсан, борлуулсан, шилжүүлсэн эсвэл ямар нэгэн байдлаар зарлагадсан, бүтээгдэхүүнд ногдуулах ёстой татвар, түүнчлэн тухайн улсын эдийн засгийн нутаг дэвсгэрт хилээр оруулж ирсэн бараанд ногдуулах импортын татвар, хураамжийн дүн мөн орно. Үүнд:

1. Нэмэгдсэн өртгийн албан татвар
2. Онцгой албан татвар (импортоор оруулж ирсэн архи, тамхины онцгой татвар орно)
3. Гадаад үйл ажиллагааны орлогын албан татвар
4. Бусад татвар (тэмдэгтийн хураамж, санхүүгийн болон хөрөнгийн шилжүүлэгтэй холбоотой татвар, хураамж, автомашин бүртгэлийн хураамж, лоттерей буюу хонжорт тоглоомын татвар, хураамж зэрэг) байна.

3.7 Бүтээгдэхүүний татаас (D.31) нь улсын нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэлд тусгагдсан татаасын хэмжээ юм.

Татаас нь Засгийн газраас (тухайн улсын эдийн засгийн харьяат биш засгийн газрын байгууллага ороод) үйлдвэрийн газруудын үйл ажиллагааны түвшин, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо хэмжээ, өртөгт үндэслэн эргэн төлөх нөхцөлгүйгээр олгодог урсгал шилжүүлэг юм.

Улсын нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэлээс авах бараа, ажил, үйлчилгээний үнийн татааст дараах татаасыг оруулна. Үүнд:

1. Эрчим хүч, дулааны алдагдлын татаас
2. Нийтийн тээврийн үйлчилгээний татаас

Бүтээгдэхүүний цэвэр татварыг тооцохдоо бараа, ажил, үйлчилгээний татвараас улсын нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэлд тусгагдсан татаасын хэмжээг хасч тодорхойлно.

4. Бараа, үйлчилгээний дансанд бүтээгдэхүүнийг үнэлж, бүртгэх

Бараа, үйлчилгээг дансанд үнэлж, бүртгэхдээ үнэлгээний дараах зарчмыг баримтална.

4.1 Нийт үйлдвэрлэлтийг үйлдвэрлэлийн явцад бүртгэж, үндсэн үнээр үнэлнэ.

Үйлдвэрлэл, түгээлтийн технологийн явцад гарсан алдагдал, хаягдлыг үйлдвэрлэлтэд оруулж тооцохгүй. Жишээлбэл, цахилгааныг үйлдвэрлээд түгээлтийн явцад гарсан алдагдал нь бүтээгдэхүүний үйлдвэрлэл биш юм.

Үйлдвэрлэлийн явц дууссаны дараа бүтээгдэхүүн, үйлчилгээг бүртгэх зарчимтай. Зарим бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл нэг тайлант хугацаанаас нөгөөд дамжих тохиолдолд тайлант хугацааны дуусаагүй үйлдвэрлэл гэж бүртгэнэ.

Өөрийн хэрэглээнд зориулсан үйлдвэрлэлт (P.12)-ийг зах зээлд борлуулсантай адилтган үзэж үндсэн үнээр үнэлнэ. Өөрийн эзэмшлийн орон сууцны хувьд мөн ижил үндсэн үнээр байна. Харин өөрийн хөрөнгөөр барьсан орон сууцны бус барилгыг нийт зарцуулсан өртгөөр нь бүртгэнэ.

Зах зээлийн бус бусад үйлдвэрлэлтийг үйлдвэрлэлийн нийт өртгөөр нь илэрхийлж, завсрын хэрэглээ (P.2), ажиллагчдын цалин, түүнтэй адилтгах орлого (D.1), үндсэн хөрөнгийн хэрэглээ (K1), үйлдвэрлэлийн бусад татвар (D.29)-ын нийлбэрээс үйлдвэрлэлийн бусад татаас (D.39)-ыг хассан дүнгээр бүртгэнэ. Зах зээлийн бус үйлдвэрлэлтэд дараах бүтээгдэхүүний үйлдвэрлэлт орно. Үүнд:

1. Засгийн газрын үйлчилгээ
2. Өрхийн аж ахуйд үйлчилдэг ашгийн бус байгууллагын үйлчилгээ
3. Өөрийн хөрөнгөөр барьсан орон сууцны бус зориулалтын барилга
4. Өөрийн хөрөнгөөр хийсэн судалгаа, шинжилгээний ажил
5. Өөрийн хэрэгцээнд зориулж, боловсруулсан програм хангамж

4.2 Завсрын хэрэглээний бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэлийн явцад шууд бүртгэж, худалдан авагчийн үнээр үнэлнэ.

Үйлдвэрлэгч нэгжийн үйлдвэрлэлийн явцад гарсан зардлыг практикт шууд бүртгэж чаддаггүй. Зарим тохиолдолд завсрын хэрэглээний бүтээгдэхүүн, үйлчилгээг төсөвлөсөн байдлаар бүртгэнэ. Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн дүнг худалдан авсан дүнгээс хасах байдлаар завсрын хэрэглээнд тооцож тусгана.

4.3 Эцсийн хэрэглээний зардлыг бараа, бүтээгдэхүүний хувьд эзэмшлийн хэлбэр солигдоход, үйлчилгээний хувьд үйлчилгээ хийж дууссаны дараа бүртгэнэ.

Худалдааны гэрээ эсвэл ижил төстэй зээлийн гэрээ (мөн санхүүгийн лизингийн нөхцөлөөр)-гээр тухайн үед хуулийн эзэмшилд шилжээгүй боловч бараа нийлүүлсэн тохиолдолд бараа, бүтээгдэхүүний зардлын дүнгээр бүртгэнэ.

Өөрийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж дууссаны дараа шууд бүртгэнэ.

Өрхийн эцсийн хэрэглээний зардлыг худалдан авагчийн үнээр үнэлнэ. Худалдан авагчийн үнэ нь бүтээгдэхүүнийг худалдан авах үеийн үнэ байна.

Цалин хэлбэрээр бэлэн бусаар олгосон бараа, үйлчилгээ нь ажил олгогчийн үйлдвэрлэсэн үндсэн үнээр бүртгэгдэх бөгөөд ажил олгогч нь үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээгээ худалдан авах үед худалдан авагчийн үнэд шилжинэ.

Өөрийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээний үлдэгдэл нь үндсэн үнээр байна.

Засгийн газрын болон өрхийн аж ахуйд үйлчилдэг ашгийн бус байгууллагын эцсийн хэрэглээний зардлыг эдгээр байгууллагын бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, үзүүлсэн үйлчилгээний үед бүртгэгдэнэ. Харин Засгийн газрын болон өрхийн аж ахуйд үйлчилдэг ашгийн бус байгууллагаас зах зээлийн үйлдвэрлэгчээр дамжуулан нийлүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх үеийн үнээр үнэлж тооцно.

Төрийн байгууллагын эсвэл өрхийн аж ахуйд үйлчилдэг ашгийн бус байгууллагын эцсийн хэрэглээний зардал (P.3) нь нийт үйлдвэрлэлт (P.1)-ийн нийлбэр дүнтэй тэнцүү байх бөгөөд зах зээлийн үйлдвэрлэгчээр дамжуулан өрхөд нийлүүлсэн бүтээгдэхүүний зардал, нийгмийн халамжийн биет хэлбэрийн тэтгэмж (D.6311 + D.63121 + D.63131)–ийг нэмж, эдийн засгийн бусад секторын зах зээлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт (P.11), зах зээлийн бус бүтээгдэхүүн үйлдвэрлэлт (P.131), өөрийн бүрдүүлсэн хөрөнгийн хуримтлал (P.12) – ыг хасаж тооцно.

Эцсийн жинхэнэ хэрэглээ. Эдийн засгийн секторын нэгжүүдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг шинэ эзэмшигчид шилжих болон үзүүлсэн үйлчилгээ үзүүлэх дуусмагц эцсийн жинхэнэ хэрэглээгээр бүртгэнэ.

Эцсийн жинхэнэ хэрэглээний зардлыг худалдан авагчийн үнээр үнэлнэ.

4.4 Хөрөнгийн нийт хуримтлал

4.4.1 Үйлдвэрлэлд ашиглах зорилгоор үндсэн хөрөнгийн эзэмшлийг шилжүүлсэн үед хөрөнгийн нийт хуримтлалыг бүртгэнэ. Мөн лизингээр хөрөнгийг эзэмшиж эхэлсэн болон өөрийн хэрэглээнд зориулсан **үндсэн хөрөнгийн хуримтлалыг** үйлдвэрлэсэн бол хөрөнгийн хуримтлалд бүртгэнэ.

Хөрөнгийн нийт хуримтлалыг худалдан авагчийн үнээр үнэлэх бөгөөд үүнд угсран суурилуулах зардал болон хөрөнгийн эзэмших эрхийг шилжүүлэхтэй холбогдох бусад зардлыг оруулна. Өөрийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн ижил төстэй үндсэн хөрөнгийг (үйл ажиллагааны ашиг эсвэл холимог орлогыг багтаасан үнэ) үндсэн үнээр үнэлнэ. Үндсэн үнээр

үнэлэх боломжгүй тохиолдолд үйлдвэрлэлд зарцуулсан өртгөөр нь бүртгэнэ.

Биет бус үндсэн хөрөнгийн хуримтлалыг дараах байдлаар үнэлнэ. Тухайлбал:

1. Ашигт малтмалын хайгуулын өрөмдлөг, цооногийн ажлын бодит зардал, агаарын тандалт эсвэл бусад судалгаа, ажлын туршилтыг хийж дуусах үеийн зардлаар үнэлнэ.
2. Компьютерын програм хангамжийг зах зээлээс худалдаж авсан тохиолдолд худалдан авагчийн үнээр үнэлнэ. Харин өрхөд үйлдвэрлэсэн тохиолдолд зардлаар нь тооцсон үндсэн үнээр үнэлнэ.
3. Эх бичмэл, бичлэг, загвар, кино, дуу бичлэг зэрэг урлаг, утга зохиолын эх бүтээлийг худалдан авагчид худалдсан үнээр үнэлнэ, харин худалдаагүй тохиолдолд үндсэн үнээр буюу үйлдвэрлэлийн зардлаар үнэлж, бүртгэнэ.

Хөрөнгийн эзэмших эрхийг шилжүүлэх зардалд үндсэн хөрөнгийг оруулаад үйлдвэрлэсэн үндсэн хөрөнгө болон газар гэх зэрэг үйлдвэрлэгдэхгүй хөрөнгийн эзэмших эрхийг шилжүүлэхтэй холбогдсон зардлыг багтаана. Энэ зардал нь үйлдвэрлэгдсэн хөрөнгийн хувьд худалдан авагчийн үнээр үнэлэгдсэн байна.

4.4.2 Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийг бүртгэх, үнэлэх нь тухайн бүтээгдэхүүний онцлогоос хамаарна.

Бэлэн бүтээгдэхүүний өөрчлөлтийг тухайн үеийн үндсэн үнээр үнэлнэ.

Дуусаагүй үйлдвэрлэлийг бэлэн бүтээгдэхүүний тухайлсан хэсэгт ногдох үндсэн үнээр үнэлнэ. ХАА-н салбарын бүтээгдэхүүний дуусаагүй үйлдвэрлэлийг зарцуулсан зардлаар тооцож, үнэлнэ.

Материаллаг эргэлтийн хөрөнгийн дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүний үлдэгдлийг худалдан авагчийн үнээр үнэлэх бөгөөд худалдан авагчийн үнэ нь тухайн бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд зориулж гадны байгууллагаар үйлчлүүлсэн тээврийн зардлыг багтаана.

Бараа солилцоогоор хийсэн бүтээгдэхүүний гүйлгээг тухайн үеийн худалдан авагчийн үнээр үнэлнэ.

4.4.3 Үнэт зүйлсийн хуримтлал. Үнэт зүйлсийн үйлдвэрлэлийг үндсэн үнээр үнэлнэ. Бусад төрлийн үнэт зүйлсийг худалдан авах үеийн худалдан авагчийн үнээр үнэлэх бөгөөд худалдааны нэмэгдэл, худалдааны төлбөр, хураамжийг оруулсан дүн байна. Өөрөөр хэлбэл, шинэ болон хуучин үнэт зүйлсийг олж эзэмшсэн тохиолдолд түүнийг тухайн үнэт зүйлсийг худалдаж авч байгаа талаас худалдаж байгаа талд төлсөн төлбөр, тухайн үнэт зүйлсийн эзэмших эрхийг шилжүүлэхтэй холбогдон гарсан бусад зардлын нийлбэрээр үнэлнэ. Энэ зардалд үнэт зүйлсийн

агентлагууд, үнэлгээчид, дуудлагын худалдаачдад төлсөн төлбөрийг багтаана. Үнэт зүйлсийг эзэмшлээсээ хасч байгаа тохиолдолд үнэт зүйлсийн нийт хуримтлалыг үнэлэхдээ шинэ үнэт зүйлс, үнэт зүйлсийг зуучлан худалдаж байгаа этгээдийн худалдааны нэмэгдэл, үнэт зүйлсийн эзэмших эрхийг шилжүүлэхтэй холбогдон гарсан зардлын нийлбэрээс бүрдэнэ.

4.4.4 Барааны экспорт, импортыг барааны эзэмшил солигдох үеэр бүртгэгдэнэ.

Барааны экспорт, импортыг ФОБ үнээр үнэлнэ. Энэ нь бараа, бүтээгдэхүүний үндсэн үнэ дээр тээвэр, худалдааны үйлчилгээний зардал зэрэг хил хүртэлх бүх зардал багтаасан үнэ, экспортын барааны цэвэр татварыг нэмсэн дүнтэй тэнцүү байна.

4.4.5 Үйлчилгээний экспорт, импорт нь үйлчилгээг үзүүлсэн тухай бүрт бүртгэгдэнэ.

Үйлчилгээний импортыг худалдан авагчийн үнээр, үйлчилгээний экспортыг үндсэн үнээр үнэлнэ.

Бараа, үйлчилгээний экспорт, импортыг Монголбанкны тухайн тайлангийн хугацааны жилийн болон улирлын төгрөгийн доллартай харьцах албан ёсны дундаж ханшны мэдээллийг ашиглаж тооцно

5. Бараа, үйлчилгээний данс байгуулах мэдээллийн эх үүсвэр

Бараа, үйлчилгээний данс байгуулахад эдийн засгийн үйл ажиллагааны үр дүнг харуулсан статистикийн албан ёсны болон захиргааны статистикийн мэдээ, тайлан, судалгааны дараахь мэдээллийн эх үүсвэрийг ашиглана. Үүнд:

- Үндэсний статистикийн хорооны эдийн үйл ажиллагааны салбаруудын улирал, жилийн тайлан
- Гаалийн ерөнхий газрын гаалийн статистик мэдээлэл
- Монголбанкны төлбөрийн тэнцлийн улирал, жилийн мэдээлэл
- Монголбанкны тухайн жилийн болон улирлын төгрөгийн доллартай харьцах албан ёсны дундаж ханшны мэдээлэл
- Үндэсний статистикийн хорооны өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа
- Сангийн яамны улсын төсвийн улирал, жилийн гүйцэтгэлийн талаарх тайлан мэдээ
- Үндэсний статистикийн хорооны төрийн бус байгууллагын орлого, зарлагын улирлын тайлан
- Үндэсний статистикийн хорооны сүм хийдийн үйл ажиллагааны улирал, жилийн тайлан
- Сангийн яамны санхүүгийн тайлан
- Татварын ерөнхий газрын албан татвар төлөгчийн тайлан

- Гаалийн ерөнхий газрын гаалийн татвар төлөгчдийн мэдээлэл зэрэг багтана.

6. Бараа, үйлчилгээний данс ба бусад макро эдийн засгийн үзүүлэлт

Үндэсний тооцооны системтэй нягт уялдаа холбоотой эдийн засгийн нэгдсэн тооцооны нэг биеэ даасан хэсэг нь төлбөрийн тэнцэл болон засгийн газрын санхүүгийн статистик юм. Төлбөрийн тэнцэл болон засгийн газрын санхүүгийн статистикийн үзүүлэлтийг бараа, үйлчилгээний дансанд тусгана.

Бараа, үйлчилгээний данс нь тайлант хугацаанд хийгдэх актив, пассивын өөрчлөлт, ажил гүйлгээ, бусад урсгал, хөрөнгийн өөрчлөлтийг нэгтгэсэн байдгаараа төлбөрийн тэнцэлтэй нягт уялддаг.

Бараа, үйлчилгээний дансны төрийн удирдлагын байгууллагын хэрэглээний зардлыг тооцоход засгийн газрын санхүүгийн статистикийн үзүүлэлтийн тусламжтайгаар гаргана.

6.1 Төлбөрийн тэнцэл

Бараа, үйлчилгээний дансны бараа, үйлчилгээний экспорт, импортын гүйлгээ нь төлбөрийн тэнцлийн бичилтээр бүртгэгдэнэ.

Төлбөрийн тэнцэл нь Үндэсний тооцооны системийн нэг бүрэлдэхүүн хэсгийн хувьд түүнтэй ижил ухагдахуун бүхий ойлголтыг хэрэглэдэг. Тухайлбал, харьяат нэгж (үйлдвэрлэгч, хэрэглэгч), ажил гүйлгээ, гадаад актив, пассивын үлдэгдлийн үнэлгээ, хөрөнгө, ажил, гүйлгээг бүртгэх хугацаа, гүйлгээг хөрвүүлэх үе шат, бодит нөөцийн (бараа, үйлчилгээ, орлого) гадаад гүйлгээний хамралт болон шилжүүлэг (урсгал болон хөрөнгийн) зэргийг энд дурьдаж болно. Мөн гадаад санхүүгийн актив, пассивын талаарх ойлголтын хувьд ч ижил байна. Тухайлбал:

- Харьяат үйлдвэрлэгч, хэрэглэгчийн тодорхойлолт нь ижил утгатай байна. Энд харьяат нэгжийн эдийн нутаг дэвсгэр ба эдийн засгийн сонирхлын төв гэсэн ойлголт ижилхэн юм.
- Зах зээлийн үнэ гэсэн ойлголт ижил утгатай байна.
- Ажил, гүйлгээний бүртгэл нь аккруэл суурьт тулгуурласан байна.
- Төлбөрийн тэнцлийн ажил, гүйлгээний болон Үндэсний тооцооны системийн гадаад эдийн засгийн дансны ангилал нь ашиглах зорилгоосоо хамааран өөр байж болно.

Нийт эдийн засгийн нэгдсэн данс болон төлбөрийн тэнцлийн урсгал гүйлгээний үзүүлэлтүүдийн хоорондох уялдааг дараахь томъёогоор илэрхийлж болно.

$$\text{ДНБ} = \text{ХХ} + \text{ЗГХ} + \text{ДХО} + \text{Е} - \text{И}$$

$$\text{УТ} = \text{Е} - \text{И} + \text{ГЦО} + \text{УЦШ}$$

$$\text{ҮНЭО} = \text{ХХ} + \text{ЗГХ} + \text{ДХО} + \text{УТ}$$

$$\text{ҮНЭО} - \text{ХХ} - \text{ЗГХ} = \text{НХ}$$

$$НХ = ДХО + УТ$$

$$НХ - ДХО = УТ$$

$$X - ДХО + ХЦШ - СБҮЦХА = САВ + ХЦШ - СБҮЦХА = ЦГХОI$$

Энд: ДНБ = дотоодын нийт бүтээгдэхүүн

ХХ = хувийн хэрэглээний зардал

ЗГХ = засгийн газрын хэрэглээний зардал

ДХО = дотоодын нийт хөрөнгө оруулалт

Е = бараа, үйлчилгээний экспорт

И = бараа, үйлчилгээний импорт

Е - И = төлбөрийн тэнцлийн бараа, үйлчилгээний тэнцэл

УТ = урсгал тэнцэл буюу сальдо

НХ = нийт хадгаламж

ГЦО = гаднаас орж ирсэн цэвэр орлого

УЦШ = урсгал цэвэр шилжүүлэг

ҮНЭО = үндэсний нийт эзэмшлийн орлого

ХЦШ = хөрөнгийн цэвэр шилжүүлэг

СБҮЦХА = санхүүгийн бус, үйлдвэрлэдэггүй цэвэр худалдан авалт

ЦГХО = цэвэр гадаад хөрөнгө оруулалт буюу гадаад эдийн засагдахь цэвэр зээл/цэвэр зээллэг

ХЦШ - СБҮЦХА = төлбөрийн тэнцлийн хөрөнгийн дансны тэнцэл байна.

Хүснэгт 2. Гадаад эдийн засгийн данс ба төлбөрийн тэнцлийн уялдаа


ҮТС, Гадаад эдийн засгийн данс	Төлбөрийн тэнцэл
Гадаад бараа, үйлчилгээний данс	Урсгал данс, Бараа, үйлчилгээ
Гадаад анхны орлого хувиарлалтын ба урсгал шилжүүлгийн данс	Урсгал данс, Орлого, урсгал шилжүүлэг
Гадаад хуримтлалын данс	
Хөрөнгийн данс	Хөрөнгө ба санхүүгийн данс, Хөрөнгийн данс
Санхүүгийн данс	Хөрөнгө ба санхүүгийн данс, Санхүүгийн данс

6.2 Засгийн газрын санхүүгийн статистик

Үндэсний тооцооны системийн үндсэн 5 секторын нэг болон төрийн удирдлагын байгууллагын ойлголт, тодорхойлолт нь засгийн газрын санхүүгийн статистикт хэрэглэгддэг ойлголттой нэг утгатай юм.

Засгийн газрын санхүүгийн статистикийн холбогдох үзүүлэлтийг Үндэсний тооцооны системийн үзүүлэлтийг боловсруулах ашиглана.

Хүснэгт 3. Үндэсний тооцооны систем ба засгийн газрын санхүүгийн статистикийн уялдаа



Хавсралт 1. Данс 0: Бараа, үйлчилгээний данс, дэлгэрэнгүй байдлаар

Нөөц		Ашиглалт	
P.1	Нийт үйлдвэрлэлт	P.2	Завсрын хэрэглээ
P.11	Зах зээлийн	P.3/P.4	Эцсийн хэрэглээний зардал / Эцсийн жинхэнэ хэрэглээ
P.12	Өөрийн хэрэглээнд зориулсан	P.31/P.41	Хувийн хэрэглээний зардал / хувийн жинхэнэ хэрэглээ
P.13	Зах зээлийн бус бусад	P.32/P.42	Хамтын хэрэглээний зардал / Хамтын жинхэнэ хэрэглээ
	Бүтээгдэхүүний цэвэр татвар	P.5	Хөрөнгийн нийт хуримтлал
D.21	Бүтээгдэхүүний татвар	P.51	Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал
D.31	Бүтээгдэхүүний татаас (-)	P.511	Биет үндсэн хөрөнгийн хуримтлал
P.7	Бараа, үйлчилгээний импорт	P.5111	Шинээр нэмэгдсэн биет үндсэн хөрөнгийн өсөлт
P.71	Барааны импорт	P.5112	Хуучин байсан биет үндсэн хөрөнгийн өсөлт
P.72	Үйлчилгээний импорт	P.5113	Хуучин байсан биет үндсэн хөрөнгөөс хасагдсан
		P.512	Биет бус үндсэн хөрөнгийн хуримтлал
		P.5121	Шинээр нэмэгдсэн биет бус үндсэн хөрөнгийн өсөлт
		P.5122	Хуучин байсан биет бус үндсэн хөрөнгийн өсөлт
		P.5123	Хуучин байсан биет бус үндсэн хөрөнгөөс хасагдсан
		P.513	Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгийн өртгийн өсөлт
		P.5131	Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгийн өөрчлөлт
		P.5132	Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгийг эзэмших эрхийг шилжүүлэхтэй холбогдон гарах зардал
		P.52	Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт
		P.53	Үнэт зүйлсийн хуримтлал
		P.6	Бараа, үйлчилгээний экспорт
		P.61	Барааны экспорт
		P.62	Үйлчилгээний экспорт

Хавсралт 2. Бараа, үйлчилгээний хураангуй дансны жишээ

Бараа, үйлчилгээний данс, 2005 он

Нөөц		Ашиглалт			
P.1	Нийт үйлдвэрлэлт	5,495,254.3	P.2	Завсрын хэрэглээ	2,765,657.5
P.11	Зах зээлийн	5,495,254.3	P.3/P.4	Эцсийн хэрэглээний зардал / Эцсийн жинхэнэ хэрэглээ	2,080,008.2
P.12	Өөрийн хэрэглээнд зориулсан		P.31/P.41	Өрхийн аж ахуйн эцсийн хэрэглээний зардал	1,712,262.9
P.13	Зах зээлийн бус бусад		P.32/P.42	Төрийн удирдлагын байгууллагын эцсийн хэрэглээний зардал	344,487.9
	Бүтээгдэхүүний цэвэр татвар	311,737.9	P.33/P.43	Төрийн бус байгууллагын эцсийн хэрэглээний зардал	23,257.4
D.21	Бүтээгдэхүүний татвар	316,972.5	P.5	Хөрөнгийн нийт хуримтлал	1,141,395.8
D.31	Бүтээгдэхүүний татаас (-)	5,234.6	P.51	Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал	849,708.8
P.7	Бараа, үйлчилгээний импорт	1,783,198.9	P.52	Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт	290,761.0
P.71	Барааны импорт	1,361,013.2	P.53	Үнэт зүйлсийн хуримтлал	926.0
P.72	Үйлчилгээний импорт	422,185.7	P.6	Бараа, үйлчилгээний экспорт	1,603,129.7
			P.61	Барааны экспорт	1,287,951.5
			P.62	Үйлчилгээний экспорт	315,178.2
Нөөц бүгд		7,590,191.2	Ашиглалт бүгд		7,590,191.2

